



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 08 сарын 30 өдөр

Дугаар А/408

Арвайхээр

2021-2023 онд Цэргийн албыг биеэр  
дүйцүүлэн хаах иргэдийн “Цэргийн дүйцүүлэх  
албаны бэлтгэл сургалт”-ыг зохион байгуулж  
явуулах тухай

Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4, Цэргийн албаны тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 30.2, 30.3, Засгийн газрын 2020 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн “Цэргийн дүйцүүлэх алба хаах иргэдийн тооны дээд хязгаарыг тогтоох тухай” 72 дугаар тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн “Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаах иргэдийн тоо, сургалтад шаардагдах төсөв батлах тухай” 2021 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 36 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоолоор батлагдсан 2021-2023 онд цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаалгахаар сумдаас ирүүлсэн саналын дагуу цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаах иргэдийн “Цэргийн дүйцүүлэх албаны бэлтгэл” шатны сургалтыг 2021 оны 09 дүгээр сарын 04-ний өдрөөс Зэвсэгт хүчний 256 дугаар ангийн сургалтын төвийн материаллаг баазыг түшиглэн 14 хоногийн хугацаатай зохион байгуулж явуулсугай.

2. Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаах 45 иргэний нэрсийг нэгдүгээр, “Цэргийн дүйцүүлэх албаны бэлтгэл” шатны сургалтад шаардагдах зардлын тооцоог хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Сургалт явуулахад шаардагдах 10,337,600 (арван сая гурван зуун гучин долоон мянга зургаан зуу) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Ц.Ганболд)-д зөвшөөрсүгэй.

4. “Цэргийн дүйцүүлэх албаны бэлтгэл” шатны сургалтад оролцох цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаагчдын үүрэг гүйцэтгүүлэх бэлэн байдал, хувийн бэлтгэлийг хангуулж, тогтоосон хугацаанд аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабт бэлэн байлгахыг сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

5. Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаагчдын сургалтыг зохион байгуулах үйл ажиллагаанд байнгын хяналт тавьж аюулгүй байдал, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Цэргийн штаб (хурандаа М.Дэлгэрсайхан)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА




А.ИШДОРЖ

011100868

D:My Doc. Zahiramj. Zasag darga

Аймгийн Засаг даргын 2021 оны 08..  
дугаар сарын 30.-ны өдрийн Ажлын дугаар  
захирамжийн хоёрдугаар хавсралт



“ЦЭРГИЙН ДҮЙЦҮҮЛЭХ АЛБАНЫ БЭЛТГЭЛ СУРГАЛТ”-ЫН  
ТӨСВИЙН ТООЦОО

№	Зардлын нэр	Зардлын тооцоо		
		Тоо	Нэг бүрийн дүн	Нийт дүн
1	Хоолны зардал /Цэрэг нормоор/	45 хүн	12.500 төгрөг /өдөрт 4 удаа, 14 хоног/	7.875.000 төг
2	Замын зардал	45 хүн	40000 төгрөг /2x20.000/ 60000 төгрөг /4x15.000/ 52000 төгрөг /4x13.000/ 228.000 төгрөг /19x12.000/ 80000 төгрөг /8x10.000/ 12000 төгрөг /2x6.000/	472.000 төгрөг
3	Хичээлийн хэрэглэл - бал - дэвтэр -принтерийн хор -бичгийн цаас -бусад бичиг хэргийн хэрэгсэл	45 ш 45 ш 1ком 2 боодол -	600 төг 1000 төг 80.000 төг 20.000 төг 50.000 төг	222.000 төгрөг
4	ШТМ, цахилгааны зардал	- ДТ - АИ-92 -Цахилгааны зардал	65*2450 70*2100 -	159.250 төгрөг 147.000 төгрөг 124.350 төгрөг Нийт: 430.600 төгрөг
5	Бусад зардал	- Аймгийн төвд явагдах сургалтад портер машин 1 нэгж гарна. ШТМ ДТ -200 л, Масло, Портер машины түрээс - Түлээ 50 шуудай мод, 1тн нүүрс - Ундны ус -. Жагсаалын дарга (1), тогооч (1) цалин - Халуун усанд оруулах	200x2000=400.000 5л*10000=50.000 50x8000=400.000 /1тн-4500/- 14тн*4500=63.000 200.000*2=400.000 1 хүнийг 1 удаа оруулахад 5000*45=225.000	1.338.000 төгрөг
<b>Дүн</b>		<b>10.337.600 төгрөг</b>		